



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН  
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН  
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 2024/ЗТ/01

Сайншанд сум

**Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, 7  
хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх  
шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох  
нарийвчилсан журмыг шинэчлэн батлах тухай**

Дорноговь аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Ж.Байгалмаа даргалж, шүүгч Д.Адъяасүрэн, шүүгч Б.Одбаяр нарыг оролцуулан, хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг батлах тухай асуудлыг хэлэлцэв.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.2.5, 19.7, 19.8, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2, 3.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг хавсралтаар баталсугай.

2.Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллаар шүүгчдийн нэрсийг нэгдсэн системд байршуулахыг Мэдээлэл технологийн мэргэжилтэнд даалгасугай.

3.Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг Тамгын газарт хүргүүлж, нийтлэг журамд заасны дагуу хяналт тавьж ажиллахыг Шүүхийн Тамгын газрын дарга /С.Бурмаа/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ж.БАЙГАЛМАА

ШҮҮГЧ

Д.АДЪЯАСҮРЭН

ШҮҮГЧ

Б.ОДБАЯР



012100025

**ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ХУВААРИЛАХ  
БОЛОН ХЭРЭГ, МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮГЧ, ШҮҮХ  
БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СУГАЛААГААР ТОМИЛОХ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хуваарилах, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхэд энэхүү "журам"-ыг баримтална.

2. Тухайн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор баталсан хэрэг хуваарилах журмыг шүүхийн мэдээллийн технологийн мэргэжилтэн системд тохируулна.

3. Системийн хэрэглэгч шүүгч, шүүхийн захиргааны ажилтан өөрийн нэвтрэх нэр, нууц үгийн аюулгүй байдлыг хариуцна.

4. Хэрэглэгч бүр шүүхийн албаны нууцын баталгаа гаргана.

5. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн / ажилтан/ эрүүгийн хэрэг, гомдол, хүсэлт, эсэргүүцэл, санал, дүгнэлт ирмэгц системд бүртгэж хэрэг хуваарилах журамд заасны дагуу системээс шүүгчид хуваарилна.

6. Хэрэглэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс гаргасан нууцад хамаарахаас бусад эрх зүйн актыг системд бүртгэж хадгална.

7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс гаргасан эрх зүйн актад хэрэглэгч зөвхөн системээс олгосон дугаарыг бичнэ.

8. Системийн ашиглалт хэвийн үйл ажиллагаанд шүүхийн тамгын газрын дарга хяналт тавина.

1.1. Хэрэг хуваарилах шүүгчийн дарааллыг тогтоох

1.1.1. Шүүхэд хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилах, хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Урьдчилан мэдэх боломжгүй
2. Тойрог дотор санамсаргүй тохиолдлоор
3. Ачаалал тэнцвэржүүлэх
4. Хуваарилагдсан болон хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн нь Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөгдөх боломжгүй
5. Хүний нөлөөллөөс ангид

6.Ил тод

7.Баримтжуулсан байх

8.Шуурхай байх.

1.1.2.Нэгдсэн системд байрших тойрогт шүүгчдийн нэрсийн дарааллыг сугалаагаар тогтоосон дараах байдлаар Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд

1.Шүүгч Д.Адъяасүрэн

2.Шүүгч Б.Одбаяр

3.Ерөнхий шүүгч Ж.Байгалмаа гэсэн дарааллаар байршуулж тойрог үүсгэх.

1.1.3.Зөрчлийн хэргийн хувьд тойрогт байгаа шүүгч нараас хувийн болон албан ажлаар богино / 3-аас доош хоног / хугацаанд явах шаардлага үүссэн тохиолдолд зөрчлийн хэргийн шийдвэрлэх хугацаа болон холбогдогч нар хөдөө орон нутгаас ирдэг байдлын улмаас хэргийг даруй шийдвэрлэх шаардлагатай тохиолдолд дараагийн шүүгчид хуваарилна.

1.3.Шүүгч шинээр нэмэгдэж ирсэн болон томилолтоор ирсэн шүүгчийг эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд сугалааны дарааллаар байршуулж тойрог үүсгэн хэргийг хуваарилах, мөн шүүгч тойргоос хасагдах тохиолдолд тухайн шүүгчид урьд хуваарилагдаад үлдсэн хэргийг шүүхэд хүлээн авсан он, сар, өдрийн дарааллаар тойрог дотор санамсаргүй байдлаар үлдэх шүүгч нарт хуваарилна.

1.4.Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон бол шүүх бүрэлдэхүүнд орох шүүгчийг харьяалах аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн шийдвэрээр томилуулна. Харин шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн ашиг сонирхлын зөрчилтэй талаар гаргасан хүсэлт нь үндэслэлтэй бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шийдвэрлүүлнэ.

1.5.Адил шатны өөр шүүхийн шүүх бүрэлдэхүүнд томилолтоор ажиллах шүүгчийг энэ журмын 1.1.2-т заасан дарааллаар томилуулахаар санал хүргүүлнэ. Томилолтоор ажиллах шүүгч шүүх хуралдаан давхацсан, өвчтэй, чөлөөтэй, сургалтад хамрагдсан тохиолдолд дараагийн шүүгчийг томилуулахаар санал хүргүүлнэ.

Хоёр. Хэрэг, гомдол, хүсэлт, санал, дүгнэлт хүлээн авах

2.1.Эрүүгийн хэрэг хүлээн авах

2.1.1.Шүүхийн тамгын газрын мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруйд нэгдсэн системд оруулан хуваарилалт хийж, дардас даран хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн, хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

2.1.2. Ажилтан хэргийг хүлээж авахдаа Эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалын 3.1.2-т заасан ажиллагааг нэг бүрчлэн шалгана. Ажилтан аргачлалын 3.1.2-т заасан ажиллагааны аль нэг нь дутуу, эсхүл алдаа, зөрчилтэй байвал заавал нөхөн гүйцэтгүүлж хүлээн авна.

2.1.3. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж, 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид /CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт/ хуулбарлан хадгалах ба түүнд шүүхийн тамгын газрын дарга тогтмол хяналт тавьж ажиллана.

2.1.4. Шүүхийн тамгын газрын мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нэгдсэн системээс хуваарилагдсан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдийн хүсэлтээр хэвлэн өгч, өгсөн тохиолдолд энэ баримтыг хэрэгт хавсаргана.

2.1.5. Шүүхэд ирсэн эрүүгийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системээс “тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчим”- аар доорх 4 аргаар хуваарилна.

а. “Ердийн журмаар” б, в, г-д зааснаас бусад бүх хэргийг хуваарилна.

б. “Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга”-аар яллагдагчийн тоо 3-аас дээш эсвэл, 5 буюу түүнээс дээш хавтаст хэргийг хуваарилна.

в. “Тодорхой төрлийн хэрэг хуваарилах арга”-аар шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх хэргийг хуваарилна /Шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хүнд ангиллын хэрэг/.

г. “Ачаалал тэнцүүлэх арга” ба “Тодорхой төрлийн хэрэг хуваарилах арга”-д заасан нөхцөлүүдийг давхар хангасан тохиолдолд “Ачаалал тэнцүүлэх арга”-аар хэргийг хуваарилна.

д. “Бусад” аргаар хуваарилна.

2.1.6 Ажилтан хэрэг хуваарилах журамд зааснаар ямар хэргийг ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг хуваарилах аргаар нарийвчилсан журамд заасны дагуу нэгдсэн системд мэдээллээ хийхэд систем өөрөө хэргийг “ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг хуваарилах” аргуудын аль нэгээр “тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчим”-аар хуваарилсныг мэдээлэл лавлагааны ажилтан шүүгчид хүлээлгэж өгнө.

2.1.7 Прокурорт буцаасан хэрэг буцаж ирвэл уг хэргийг буцаасан шүүгчид хуваарилах, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаасан хэргийн шийдвэр давж заалдах шатны шүүхээр хянагдаад хүчингүй болж буцаж ирвэл хэргийг буцаасан шүүгчид хуваарилах,

2.1.8 Анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн шийдвэр давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол хэргийг өмнө шийдвэрлэсэн шүүгчийг алгасаж, шүүгчид тойрог дотроос санамсаргүй байдлаар хуваарилах,

2.1.9 Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг тухайн хэргийг өмнө нь шийдвэрлэсэн шүүгчид өгөх,

2.1.10 Шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой ЭХХШТХуулийн 37.1-37.12 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг сугалаагаар тогтоосон дарааллаар тойргоор хуваарилах,

2.1.11 Харьяалал тогтоож ирүүлсэн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүчингүй болж ирсэн хэргийг “2.1.5 дахь хэсэгт заасан” аргуудын аль нэгээр тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар хуваарилна

2.1.12 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.2 дугаар зүйлийн 1.6 дахь заалтад зааснаар эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах тохиолдолд мөн хуулийн 29.2 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

2.1.13.Хуваарилагдсан хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгчийг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, үндэслэл үүссэн, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд тухайн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилно. Зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг дахин хуваарилахдаа тухайн шүүгчийг алгасан, бусад шүүгч нарт тойрог дотор санамсаргүй байдлаар хуваарилах сонголтыг нэгдсэн системд тохируулсан байна.

2.1.14.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу тухайн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэх шүүгч өөрчлөгдөж байгаа тохиолдолд программд өөрчилсөн үндэслэл, шийдвэрийн талаар шаардагдах өгөгдлүүдийг оруулах бөгөөд энэ талаарх баримтын хувийг программ хангамж хариуцсан ажилтанд хадгалуулж, жил бүр архивт шилжүүлнэ.

2.1.15.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шүүгч дангаар гаргасан шийдвэрийн талаарх гомдлыг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч шийдвэрлэнэ.

2.1.16.Ажилтан давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хянан шийдвэрлээд ирүүлсэн хэргийг хүлээн авч, аргачлалын 3.1.4-т заасны дагуу баталгаажуулж, Бүртгэл 4, Бүртгэл 5-д бүртгэж, Ерөнхий шүүгч болон хэргийг шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүнд танилцуулж, шийдвэрлэсэн шүүгчид даруй хүлээлгэн өгч, холбогдох бүртгэлд гарын үсэг зуруулна.

2.1.17.Тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай болон бусад хүндэтгэн үзэх шалтгаантай үед прокурорт буцаасан хэрэг дахин ирсэн, адил шатны шүүхээс харьяаллын дагуу шилжүүлсэн, эсвэл хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийг Бүртгэл 1-д, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэргийг Бүртгэл 13-д, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэргийг Бүртгэл 42-т, харьяалал тогтоолгож ирүүлсэн хэргийг Бүртгэл 14-т ажилтан тус тус бүртгэж, аргачлалын 3.1.4-т заасны дагуу баталгаажуулж, Хэрэг хуваарилах

нарийвчилсан журамд заасны дагуу системээс хуваарилсныг шүүгчид даруй хүлээлгэн өгч, холбогдох бүртгэлд гарын үсэг зуруулна.

2.1.18. Ажилтан давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэргийг системд бүртгэхдээ давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон буюу прокурор, оролцогчийн хяналтын журмаар болон Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол, эсэргүүцэл гаргах хугацаа дууссаны дараа бүртгэж, хэрэг хуваарилах журмын 2.1.8-д заасны дагуу системээс хуваарилна.

## 2.2. Зөрчлийн хэрэг хүлээн авах

### 2.2.1 Ажилтан прокурорын дүгнэлт, оролцогчийн гомдол, зөрчил шалган

шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан болон Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5 дугаар зүйлд заасан зөрчлийн хэргийг Бүртгэл 20-д бүртгэж аргачлалын 3.1.4-т заасны дагуу дардас дарж баталгаажуулж хүлээн авна.

2.2.2 Ажилтан аргачлалын 3.4.2-т зааснаар зөрчлийн хэргийг хэрэг хуваарилах журмын 1.1.2-т заасны дагуу системээс хуваарилмагц шүүгчид хүлээлгэн өгч Бүртгэл 20-д гарын үсэг зуруулж холбогдогчийг тухайн шүүгчийн туслахад хүлээлгэн өгнө.

2.2.3 Анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн шийдвэр давж заалдах шатны шүүхээс хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол хэргийг өмнө шийдвэрлэсэн шүүгчийг алгасаж, журмын 1.1.2-т заасан дарааллаар шүүгчид хуваарилна.

2.2.4 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэргийг хэлэлцэх шүүх хуралдааныг завсарлуулж, хэрэг бүртгэлтийн нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгасан хэрэг буцаж ирсэн тохиолдолд түүнийг анх хүлээн авсан шүүгч шийдвэрлэнэ.

2.2.5. Шүүгч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай болон бусад хүндэтгэн үзэх шалтгаантай үед шүүх хуралдааныг завсарлуулсан зөрчлийн хэрэг дахин ирсэн тохиолдолд дараагийн шүүгч нарт нарийвчилсан журмын 1.1.2-д заасан дарааллаар хуваарилна.

## 2.3. Таслан сэргийлэх арга хэмжээний санал, хүсэлтийг хүлээн авах

2.3.1 Сэжигтнийг баривчлах, яллагдагчийг тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах тухай прокурор, оролцогчийн санал, хүсэлтийг Бүртгэл 16- д бүртгэж, аргачлалын 3.1.4-т заасны дагуу шүүгчийн туслах баталгаажуулж, хүлээн авна.

2.3.2 Сэжигтнийг баривчлах, яллагдагчийг тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах тухай прокурор, оролцогчийн санал, хүсэлт, албадан саатуулах хугацаа сунгуулах

хүсэлтийг хүлээн авч Ерөнхий шүүгчээс бусад шүүгчид системд тойрог дотор санамсаргүй байдлаар хуваарилагдсан даруй шүүгчид хэргийн хамт хүлээлгэн өгч Бүртгэл 16-д гарын үсэг зуруулна.

2.3.3. Шүүгч ээлжийн амралттай болон бусад шалтгааны улмаас тухайн шүүхэд Ерөнхий шүүгчээс өөр шүүгч ажиллаагүй тохиолдолд сэжигтнийг баривчлах, яллагдагчийг тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах тухай прокурор, оролцогчийн санал, хүсэлт, албадан саатуулах хугацаа сунгуулах хүсэлтийг Ерөнхий шүүгч хүлээн авч шийдвэрлэнэ. Уг шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд хуульд заасны дагуу Ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.

#### 2.4 Гомдол, хүсэлт, дүгнэлт хүлээн авах

2.4.1. Тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой оролцогч болон талуудын гомдол хүсэлтийг хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчид, бусад гомдол, хүсэлтийг Ерөнхий шүүгчийн туслах систем болон Бүртгэл 2-т бүртгэж, аргачлалын 3.1.4-т заасны дагуу дардас дарж баталгаажуулж шүүгч болон Ерөнхий шүүгчид даруй хүлээлгэн өгнө.

2.4.2. Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаатай холбоотой гаргасан гомдол, хүсэлт, прокурорын дүгнэлтийг шүүгчийн туслах систем болон Бүртгэл 43, Бүртгэл 18-д тус тус бүртгэж, аргачлалын 3.1.4-т заасны дагуу баталгаажуулж, нарийвчилсан журмын 1.1.2-т заасан тойрог дотор санамсаргүй байдлаар шүүгчид даруй хүлээлгэн өгнө.

#### Гурав. Бусад

3.1. Шүүгч ээлжийн амралт авах тохиолдолд түүнд хуваарилагдсан үлдэгдэл хэргийг дараагийн шүүгч нарт тойрог дотор санамсаргүй аргаар нэгдсэн системээс хуваарилна.

3.2. Шүүгчид ээлжийн амралт эхлэхээс ажлын 7 хоногийн өмнө хэрэг хуваарилалтыг зогсоох, ажилд орсон өдрөөс эхлэн хэрэг хуваарилах асуудлыг шийдвэрлэнэ.

3.3. Шүүгч ээлжийн амралттайн улмаас хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд ээлжийн амралттай байгаа шүүгчийг тухайн орон нутагт байгаа тохиолдолд шүүх бүрэлдэхүүнд томилж болно.

3.4. Шүүгч ажлын 5-14 хоногийн хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон тохиолдолд хэрэг хуваарилахгүй бөгөөд түүнд хуваарилагдсан хэргээс шүүх хуралдаан товлон зарласан хэргийг дараагийн шүүгч нарт системээс “тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчим”- аар ердийн журмаар, ачаалал тэнцүүлж, тодорхой төрлийн хэрэг хуваарилах аргуудын аль нэгээр хуваарилна. Харин шүүх хуралдаан товлон зарлаагүй бол дээрх хугацаанд хэрэг өөр дээр нь хэвээр үлдэж тухайн шүүгч өөрөө шийдвэрлэнэ.

3.5.Шүүгч 14 хоногоос дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон тохиолдолд тухайн шүүгчийн үлдэгдэл хэргийг системээс “тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчим”- аар хуваарилна.

3.6.Шүүгч шилжсэн тохиолдолд өмнө нь хуваарилагдсан үлдэгдэл хэргийг үлдсэн шүүгч нарт зөвлөгөөний тогтоолын 2.1-д заасан дарааллаар хуваарилна.

3.7.Шүүгч шилжсэн тохиолдолд түүний шийдвэрлэсэн хэрэгт шүүгчийн захирамж, албан бичиг, гүйцэтгэх хуудас болон хуульд заасны дагуу бичигдэх шийдвэрийг шинээр шүүгч томилогдох хүртэл хугацаанд Ерөнхий шүүгч гаргана.

3.8.Шүүгч солигдсон тохиолдолд түүнд хуваарилагдсан үлдэгдэл эрүүгийн хэрэг, зөрчлийн хэрэг, гомдол, хүсэлт, прокурорт буцаасан хэргийг шинээр ирсэн шүүгчид шилжүүлнэ.

3.9.Энэхүү журмыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зааснаар олон нийтэд нээлттэй, шүүхийн цахим хуудсанд байршуулна.

3.10.Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох программын ажиллагаа, программ дээр хийгдсэн үйлдэл бүрийг дүрс бичлэг хийх бөгөөд программд хандсан хэрэглэгчийн эрх, үйлдлийн дэлгэрэнгүй мэдээлэл, бүртгэл нь хадгалагдаж, тэдгээрт хөндлөнгийн хяналт хийгдэх боломжтой байна.

---o0o---